



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 128

Пионер толгой

“Ёс зүй хандлага зөвтэй төрийн алба-3”
аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүй хандлага зөвтэй төрийн алба-3” аян зарлах тухай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачлагыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Ёс зүй хандлага зөвтэй төрийн алба-3” аяныг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Г.Сүхбаатар	Эрүүл мэндийн төвийн дарга
	П.Цэрэндолгор	Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Э.Цэрэнханд	Цэцэрлэгийн эрхлэгч
	Б.Бадамцэцэг	Соёлын төвийн дарга
	Ц.Орхонтуул	Сургуулийн нийгмийн ажилтан
Нарийн бичгийн дарга:	Т.Цагаанлянх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
	С.Цэцгээ	Дотуур байрын багш
	Б.Мөнхдалай	Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.“Ёс зүй хандлага зөвтэй төрийн алба-3” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

642201231

3.Төлөвлөгөөний дагуу санал, санаачлагыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсэг (Р.Гантулга), төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4.“Ёс зүй хандлага зөвтэй төрийн алба-3” аяны хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээний тайланг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны дотор ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д ирүүлэхийг байгууллагын дарга, эрхлэгч нарт хариуцуулсугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



Сумын Засаг даргын 2023.03.03-ний өдрийн
оны 03... сарын 20-ний өдрийн
Ардгаар тоот захирамжийн хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН "ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА ЗӨВТЭЙ ТӨРИЙН АЛБА-3"
АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 он

Пионер толгой

№	Зохيون байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хариуцан зохион байгуулагч
1	2	3	4	5	6
Зорилт 1. "Төрийн албаны эрх зүйн шинэчлэл" сэдэвт сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах					
1	"Төрийн албаны тухай хууль, түүний нэмэлт өөрчлөлтийн тухай"	2023 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	Сургалт тус бүрт хамрагдвал зохих албан хаагчдын 90-ээс дээш хувийг хамруулсан байна.	Төрийн албаны тухай хууль, журмуудын талаар албан хаагчид мэдлэг мэдээлэлтэй болсон байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
2	Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалт зохион байгуулах	2024 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл		Шинээр томилогдсон албан хаагчид төрийн албаны талаар ойлголт, мэдээлэлтэй болсон байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
3	"Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, манлайлал" сэдэвт сургалт	2025 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	Нийт албан хаагчдын 90-ээс дээш хувийг хамруулсан байна.	Төрийн албан хаагчдын манлайлал сайжирсан байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
4	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүний хэрэгжилтийг зохион байгуулах тухай" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг хийх	2026 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	ХАБЭА-н зөвлөлийг шинэчилж, улирал бүр хуралдан, арга хэмжээ зохион байгуулсан байна.	Ажлын байрны орчин нөхцөл сайжирч, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах боломж бүрдсэн байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар

1	2	3	4	5	6
5	"Манай байгууллагын соёл" арга хэмжээг зохион байгуулж, архигүй хамт олон болох зорилтыг хэрэгжүүлэх	2027 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	Баяр ёслол, хамт олныг хамарсан үйл ажиллагааг архигүй тэмдэглэж хэвшсэн байна.	Төрийн албан хаагчдын архидалт буурч, архигүй баяр ёслолыг тэмдэглэж хэвшсэн байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
6	"Манай байгууллага- Миний гэр бүл" сэдэвт байгууллагын албан хаагчдын манлайллыг сайжруулах 3 үеийн уулзалт арга хэмжээг зохион байгуулах	2028 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	Үр нөлөөтэй арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан байна.	Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоо сайжирч, албан хаагчдын ажилдаа хандах хандлага, манлайлалд зэрэг өөрчлөлт гарган байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
Зорилт 2. "Төрийн алба-Цахимжилт" төрийн албаны хүний нөөцийн системийн хөтөлөлтийг сайжруулах					
7	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолооор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх 7 хоногийн аяныг байгууллагын хүрээнд зохион байгуулах	2023 оны 3 дугаар сард	Байгууллагын нийт албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу шинэчилсэн байна.	Албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлт сайжирсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар
8	Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд мэдээллийг үнэн зөв оруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	"ХНУМТ" цахим сангийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн байна.	Цахим сангийн мэдээллийн үнэн бодитой байдал, ашиглалт сайжирсан байна.	Байгууллагын дарга эрхлэгч нар

1	2	3	4	5	6
Зорилт 3. "Төрийн албаны ёс зүй, хандлага, соёлын шинэчлэл" сэдэвт сургалт, зөвлөгөөн зохион байгуулах					
9	Байгууллагын үйл ажиллагааны сайн туршлагыг түгээх, олон нийтэд сурталчилах	2023 оны 3 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 01 хүртэл	Байгууллагын сайн туршлагыг түгээх, олон нийтэд сурталчилсан байна.	Үйлчилгээний чанар, хүртээмж, ажлын бүтээмж дээшилсэн байна.	Байгууллагын дарга, эрхлэгч нар
10	"Төрийн албаны ёс зүй, хандлага, соёлын шинэтгэл" сэдэвт сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	2023 оны 4, 9 дүгээр саруудад	Сургалт зөвлөгөөнд албан хаагчдыг хамруулсан байна.	Албан хаагчдын ёс зүй, хандлага сайжирсан байна.	ЗДТГ-ын дарга Р.Гантулга, байгууллагын дарга, эрхлэгч нар

_____оОо